



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 1391

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 2.3, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.8, 5.1.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн арга хэмжээг угтан хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбай, нэрэмжит төгөл, цэнгэлдэх хүрээлэн, улсын чанартай авто зам дагуу тарьсан мод, сөөгийг услах усны төлбөрт шаардагдах зардлыг баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 4,445,200 (Дөрвөн сая дөрвөн зуун дөчин таван мянга) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Дундговь ноогооруулъя” төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Л.Доржбат), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4822111098